

# СТАТИСТИКИЙН ТАНИЛЦУУЛГА



Дүүргийн эдийн засаг,  
нийгмийн байдал

2016 он  
7-р сар

## АГУУЛГА

## Хуудасны


## тоо

1. ДҮҮРГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2
2. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	4
3. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ	7
4. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	8
5. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	9
6. НИЙГМИЙН ДААТГАЛ	10
7. НИЙГМИЙН ХАЛАМЖ	11
8. АЖ АХУЙН НЭГЖ	11
9. АЖ ҮЙЛДВЭР	12
10. ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ	13
11. ИРГЭНИЙ БҮРТГЭЛ	14
12. ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ	14
13. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	15
14. МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТ	16
15. УЛААН ЗАГАЛМАЙ	17
16. ЦЭРГИЙН ШТАБ	17
17. АХМАДЫН ХОРОО	17
18. СОЁЛ УРЛАГ	18
19. ЗАХИРГААНЫ МЭДЭЭ	18
20. ГЭМТ ХЭРЭГ	19
21. ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ ЗӨРЧИЛ	19
22. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ ГАМШИГ	20

Хүснэгт 1. Дүүргийн үндсэн үзүүлэлт. 2016 оны 7 сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015 он	2016 он
Суурин хүн ам /жилийн эцэст/	Хүн	159514	154819
Төрөлт	Тоо	2729	2444
Шинээр төрсөн хүүхэд	Тоо	2758	2465
Нас баралт	Тоо	484	414
Халдварт өвчин	Тоо	3331	3254
Ажилгүйчүүд	Хүн	2879	1916
Бүртгэгдсэн гэмт хэрэг	Тоо	1356	1500
Дүүргийн төсвийн орлого	Сая төгрөг	34971.8	39753.8
Дүүргийн төсвийн зарлага	Сая төгрөг	30993.5	36325.4
Валютын ханш	1US\$=₮	1985.0	2265.0


Хүснэгт 2. Насны бүлгээр тооцсон зарим үзүүлэлтүүд. 2015 оны жилийн эцсээр



Хүснэгт 3. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүд дүүргээр

	Хэмжих нэгж	2015 оны 7 сарын байдлаар					2016 оны 7 сарын байдлаар				
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /1 кв км-т ногдох хүн/	тоо	284	Баянгол	7189	Налайх	51	291	Баянгол	7087	Налайх	53
			Чингэлтэй	1817	Багануур	46		Чингэлтэй	1762	Багануур	46
			Сүхбаатар	666	Багахангай	28		Сүхбаатар	669	Багахангай	30
Ажилгүйчүүд /хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох/	0\000**	137	Налайх	480	Сонгинохайрхан	79	138	Багахангай	477	Хан-Уул	127
			Багахангай	394	Баянгол	79		Налайх	439	Сонгинохайрхан	115
			Багануур	238	Баянзүрх	76		Багануур	336	Баянзүрх	88
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	15	Багахангай	23	Чингэлтэй	10	17	Налайх	26	Баянгол	11
			Сонгинохайрхан	14	Баянгол	10		Баянзүрх	18	Хан-Уул	10
			Баянзүрх	14	Багануур	8		Сүхбаатар	15	Багахангай	-
Халдварт өвчнөөр өвчлөгсөд /10000 хүн тутмаас/	0\000	234	Баянзүрх	263	Хан-Уул	182	226	Баянзүрх	264	Сүхбаатар	184
			Сонгинохайрхан	213	Багануур	150		Багануур	228	Хан-Уул	179
			Чингэлтэй	211	Багахангай	65		Чингэлтэй	207	Багахангай	52
Төсвийн орлого, зарлагын харьцаа /зарлага=100/	мян.төг	103	Сүхбаатар	128	Багануур	81	88	Сүхбаатар	122	Багануур	85
			Чингэлтэй	126	Налайх	78		Чингэлтэй	120	Налайх	72
			Хан-Уул	119	Багахангай	75		Хан-Уул	119	Багахангай	60
Гэмт хэрэг /18-аас дээш насны 10000 хүнд ногдох/	тоо	120	Сүхбаатар	198	Сонгинохайрхан	95	127	Сүхбаатар	201	Сонгинохайрхан	91
			Чингэлтэй	133	Хан-Уул	90		Чингэлтэй	144	Багануур	88
			Баянзүрх	122	Багахангай	67		Баянгол	144	Багахангай	64

Тайлбар: \* - промилль \*\* - продицил




### ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2016 оны 7-р сарын хэрэглээний үнийн индекс 2015 оны мөн үетэй харьцуулахад 0.1 хувиар өсч, өмнөх сартай харьцуулахад 0.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 4. Хэрэглээний үнийн индекс

Бараа үйлчилгээний бүлэг	Жин	<u>2016.07</u> <u>2015.07</u>	<u>2016.07</u> <u>2016.06</u>
Ерөнхий индекс	101.6	<b>100.1</b>	<b>99.5</b>
Хүнсний бараа, ундаа, ус	110.0	94.2	98.5
Согтууруулах ундаа, тамхи	103.1	103.1	101.5
Хувцас, бөс бараа	99.5	100.5	99.6
Орон сууц, ус, түлш, цахилгаан	92.5	98.2	100.0
Гэр ахуйн тавилга, бараа	100.3	101.6	99.2
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	106.6	109.0	100.8
Тээвэр	97.6	98.0	99.4
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.7	100.7	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	98.6	99.9	100.0
Боловсролын үйлчилгээ	100.0	123.6	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	100.0	101.6	100.0
Бусад бараа, үйлчилгээ	100.2	100.7	100.1

Зураг1. Хэрэглээний үнийн өсөлт



Хэрэглээний үнийн индекс 2016 оны 7-р сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.1 хувиар өсөхөд согтууруулах ундаа 3.1 хувь, хувцас, бөс бараа 0.5 хувь, гэр ахуйн бараа, тавилга 1.6 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 9.0 хувь, боловсролын үйлчилгээ 23.6 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 1.6 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 0.7 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.


Хүснэгт 5. Бараа бүтээгдэхүүний дундаж үнэ, төгрөг / 7 сар/

Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2012	2013	2014	2015	2016
Алтан тариа 1-р зэрэг	кг	700	750	750	1000	1100
Атар талх	ш	650	780	1000	1067	1167
Цагаан будаа	кг	1600	1700	2230	2200	2200
Шар будаа	кг	1400	1400	1770	1700	1400
Хонины мах	кг	7100	7850	7200	7500	6600
Үхрийн мах	кг	7300	8450	8270	8267	7600
Адууны мах	Кг	5800	6500	6430	6100	5167
Тахианы гуя	кг	4000	5500	6530	6667	6267
Сүү задгай	л	800	900	1000	1050	1233
Хорхой ааруул	кг	8000	7000	10330	9000	9333
Өндөг	ш	250	260	350	300	247
Ургамлын тос	л	2600	2600	3000	3300	3333
Алим, кг	кг	3200	3000	3500	4500	3867
Банан, шар	кг	3000	4000	5000	5500	4833
Төмс	кг	1000	800	1270	1500	1100
Лууван	кг	2500	1500	2500	1867	2833
Сонгино	кг	1000	1400	1400	1000	1300
Элсэн чихэр	кг	1500	1500	1800	1700	1767
Цэвэр усны үнэ тоолуургүй 1хүний	хүн	3201.6	3201.6	4705.8	4705.8	4705.8
Эдийн саван ОК	ш	450	450	533	600	600
Угаалгын нунтаг "ОМО"	ш	580	650	800	833	850
Аяга, таваг угаагч шингэн, "Fairy"	ш	2750	3000	3600	4067	4100


Зураг 2. Алтан тариа дээд гурил, атар талхны үнэ, 2011-2016 он




Зураг 3. Нэг кг хонь, үхрийн махны дундаж үнэ, 2012-2016 он



Зураг 4. Нэг кг лууван, төмсний дундаж үнэ, 2011-2016 он



Зураг 5. Нэг кг сонгино, байцааны дундаж үнэ, 2011-2016 он



Зураг 6. Шатахууны үнэ, 2011-2016 он





## ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

**Төсвийн орлого:** Орон нутгийн төсвийн нийт орлого, тусламжийн дүн 2016 оны 7 дугаар сарын байдлаар 39753.8 сая төгрөг, нийт зарлага цэвэр зээлийн дүн 36325.4 сая төгрөг болж, орон нутгийн төсвийн нийт тэнцэл 3428.4 сая төгрөгийн хэмнэлттэй гарсан байна.

Орон нутгийн нийт төсвийн төлөвлөгөөний биелэлтийг нэр тус бүрээр нь доорх хүснэгтэнд харуулав.

Хүснэгт 6. Төсвийн урсгал орлого


Үзүүлэлт	Төлөвлөгөө /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Зөрүү /мян.төг/	Биелэлт
Нийт орлогын дүн	57156295.7	39753826.1	-17402469.6	30.4
Урсгал орлого	24202678.2	19358453.7	-4844224.5	20.0
1.Татварын орлого	23664200.0	18699829.7	-4964370.3	21.0
Орлогын албан татвар	12000000.0	7457065.1	-4542934.9	37.9
Өмчийн татвар	64200.0	17840.0	-46360.0	72.2
Бусад татвар	11600000.0	11224924.6	-375075.4	3.2
2.Татварын бус орлого	538478.2	658624.0	120145.8	22.3
Тусламжийн орлого	32953617.5	20395372.4	-12558245.1	38.1

Төсвийн төлөвлөгөөний биелэлт татварын бус орлогоос бусад нэр төрөл тус бүр дээр төлөвлөснөөс дутуу бүрдсэн байна.

### Төсвийн зарлага:

Орон нутгийн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүн 2016 оны 7 дугаар сарын байдлаар 36325.4 сая төгрөг болж төлөвлөсөн хэмжээнээс 28138.5 сая төгрөгөөр буюу 43.7 хувиар төсвийн зардлыг хэмнэсэн байна.

Зураг 8. Төсвийн зардал



Төсвийн нийт зарлагын 33.7 хувийг цалин хөлс, 3.7 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 42.6 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 5.0 хувийг татаас, 8.7 хувийг урсгал шилжүүлэг, 6.3 хувийг хөрөнгө оруулалтын зардал тус тус эзэлж байна.



Хүснэгт 7. Төсвийн зарлага

Үзүүлэлт	Төлөвлөгөө /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Зөрүү /мян.төг/	Биелэлт
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	64463895.9	36325394.1	-28138501.8	43.7
А. Урсгал зардлын дүн	56491798.5	34016940.7	-22474857.8	39.8
1. Бараа үйлчилгээний зардал	47232047.5	29039809.8	-18192237.7	38.5
1.1 Цалин хөлс	19845195.0	12226132.4	-7619062.6	38.4
1.2 НДШ хураамж	2221933.3	1356018.8	-865914.5	39.0
1.3 Бараа үйлчилгээний бусад зардал	25164919.2	15457658.6	-9707260.6	38.6
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	0.0	0.0	0.0	-
3. Татаас ба урсгал шилжүүлэг	9259751.0	4977130.9	-4282620.1	46.2
3.1 Татаас	9259751.0	1809175.9	-7450575.1	80.5
3.2 Урсгал шилжүүлэг	0.0	3167955.0	3167955.0	-
Б. Хөрөнгийн зардал	7972097.4	2308453.5	-5663643.9	71.0
1. Хөрөнгө оруулалт	7972097.4	2308453.5	-5663643.9	71.0


2016 оны 7-р сарын байдлаар сарын эхэнд орон нутгийн өглөггүй байсан бөгөөд тайлант хугацаанд нэмж 1025.0 төгрөгийн өглөг үүссэн байна.



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Хөдөлмөрийн хэлтсийн 2016 оны 7-р сарын мэдээгээр ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй 1916 иргэн бүртгүүлсэн байна. Нийт ажил хайж байгаа эмэгтэйчүүд 1137 буюу 59.3 хувь, хөгжлийн бэрхшээлтэй иргэд 20 буюу 1.0 хувь байна. Насны бүлгээр авч үзвэл нийт ажил хайж байгаа иргэдийн 221 буюу 11.5 хувь нь 15-24 насны, 800 буюу 41.8 хувь нь 25-34 насны, 468 буюу 24.4 хувь нь 35-44 насны, 299 буюу 15.6 хувь нь 45-54 насны, 128 буюу 6.7 хувь нь 55 дээш насны хүмүүс байна.

Зураг 10. Ажил идэвхитэй хайж байгаа иргэдийн тоо боловсролын түвшингээр





### ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ


Дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн мэдээгээр 2016 оны 7 дугаар сарын байдлаар дүүргийн хэмжээнд 2444 эх амаржиж, 2465 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс амаржсан эхийн тоо 202 буюу 10.5 хувь, амьд төрсөн хүүхэд 208 буюу 10.7 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 8. Эмнэлгийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд

Үзүүлэлт		2015.07	2016.07	Зөрүү	Хувь/%/
Нийт үзлэг		427890	458396	30506	7.1
Үүнээс:	Урьдчилан сэргийлэх	169650	174895	5245	3.1
	Амбулаторид	122375	134609	12234	10.0
	Диспансерийн хяналт	53587	56620	3033	5.6
	Гэрийн үзлэг	79617	89450	9833	12.3
	Гэрийн дуудлагын үзлэг	2661	2822	161	6.0
Аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг		136328	156669	20341	14.9
Өрхийн эмчийн үзлэг		291562	301770	10208	3.5
Бүртгэгдсэн өвчлөл		19134	29219	10085	52.7
Үүнээс:	Шинэ	12527	18622	6095	48.6
	Хуучин	6607	10597	3990	60.4
Бүртгэгдсэн хорт хавдар		22	41	19	86.4
Осол гэмтэл		287	330	43	15.0
Хэвтсэн өвчтөн		5562	5935	373	6.7
Эмнэлгийн нас баралт		14	26	12	85.7
Хоног болоогүй нас баралт		6	6	0	-
Эмчлэгдсэн өвчтөн		5472	5915	443	8.1
Түргэн тусламжийн дуудлага		2337	2274	-63	2.7

2016 он гарсаар 414 хүн нас барсан нь өнгөрсөн оны мөн үеэс 70 хүнээр буюу 14.4 хувиар буурсан байна. Нийт нас баралтын дотор нялхсын эндэгдэл 31 буюу 7.5 хувь, 1-5 насны хүүхдийн эндэгдэл он гарсаар 4 бүртгэгдсэн байна. Нялхсын эндэгдэл өнгөрсөн оны мөн үеэс 14.8 хувиар өссөн байна. 2016 оны 7 сарын байдлаар 458.4 мян.хүн үзлэгт хамрагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс 30.5 мян.хүн буюу 7.1 хувь, эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүний хүний тоо 5935 болж өмнөх оны мөн үеэс 5.7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 10. Нийт үзлэг, төрлөөр



Хүснэгт 9. Халдварт өвчин

Үзүүлэлт	2015.07	2016.07	Зөрүү	Хувь/%/	
Халдварт өвчин	3331	3254	-77	2.3	
Үүнээс:	Гепатит	36	15	-21	58.3
	Цусан суулга	77	128	51	66.2
	Сальмоннез	4	1	-3	75.0
	Хоолны хордлого	12	76	64	5.3 дахин
	Менингит	0	0	0	-
	Салхин цэцэг	215	187	-28	13.0
	Гахайн хавдар	3	16	13	4.3 дахин
	Улаан эсэргэнэ	22	68	46	2.1 дахин
	Ёлом	4	6	2	50.0
	Улаан бурхан	2053	1755	-298	14.5
	Улаанууд	5	0	-5	100.0
	Бруцеллэз	1	1	0	-
	Гар, хөл, ам	87	302	215	2.4 дахин
	Тэмбүү	350	291	-59	16.8
	Заг хүйтэн	85	105	20	23.5
	Трихомониаз	64	58	-6	9.4
	Мөөгөнцөр	69	19	-50	72.5
	Сүрьеэ	228	212	-16	7.0
Бусад	16	10	-6	37.5	

Дүүргийн хэмжээнд 2016 оны 7 сарын байдлаар бүртгэгдсэн халдварт бус өвчлөл 29.2 мянга болж өнгөрсөн оны мөн үеэс 52.7 хувиар өссөн байна. Халдварт өвчин 3254 бүртгэгдсэн нь өмнөх оноос 2.3 хувиар өссөн нь хоолны хордлогын халдвар эрс өссөнтэй холбоотой байна. Бэлгийн замын халдварт өвчин нийт халдварт өвчний 14.5 хувийг эзэлж байна. БЗХӨ өнгөрсөн оны мөн үеэс 16.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



НИЙГМИЙН ДААТГАЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2016 оны 7-р сард төсвийн 213 байгууллагын 20043 албан хаагчид, хувийн хэвшлийн 3602 аж ахуйн нэгжийн 57761 албан хаагчид, сайн дурын 11058 иргэн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байна. Эрүүл мэндийн даатгалд 39262 иргэн хамрагдсан. Үүнээс төр эрүүл мэндийн даатгалыг хариуцсан даатгуулагч 25787 байна.

Хүснэгт 10. Тэтгэвэр олголт

	Хүний тоо	Олгосон тэтгэмж	
		Төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/
Өндөр настан	15306	37604.0	35580.8
Тахир дутуу	3086	4996.5	5068.0
Тэжээгчээ алдсан	962	1447.7	1662.2
Дүн	19354	44048.2	42311.0



## НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2016 оны 7-р сарын байдлаар нийгмийн халамжийн сангийн нийт орлогын 16.0 хувийг жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмжинд, 3.1 хувийг хүнс тэжээл хөтөлбөрийн дансны санхүүжилтын орлогод тус тус хуваарилсан байна.

### Хүснэгт 11. Нийгмийн халамжийн сангийн үзүүлэлт, сая.төг

Үзүүлэлт	Үнийн дүн
Нийгмийн халамжийн сангийн орлого	7038.2
1. Хүн амын хөгжлийг дэмжих чиглэлийн төсвийн санхүүжилт	1367.4
а) Жирэмсэн нярай хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж	1128.1
б) Алдарт эхийн одонгийн тусламж	-
с) Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	-
д) ОНОТХҮ үйлчилгээний санхүүжилтын орлого	22.5
е) Хүнс тэжээл хөтөлбөрийн дансны санхүүжилтын орлого	216.8
2. Нийгмийн халамжийн сан	5660.0
а) Төсвийн санхүүжилтын орлого	5660.0
б) Бусад орлого	-
3. Хүүгийн орлого	10.8
Зарлагын нийт дүн	6026.2
1. Нийгмийн халамжийн сан	4879.9
2. Жирэмсэн нярай хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж	1146.3
3. Алдарт эхийн одонгийн тусламж	-
4. Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	-
5. Хүнс тэжээлийн хөтөлбөр	-
6. ОНОТХ. үйлчилгээ	-

Нийгмийн халамжийн сан нь 2572 хүнд халамжийн тэтгэвэр, 2374 хүнд асаргааны мөнгөн тэтгэмж, 8573 хүнд Ахмад настаны хөнгөлөлт тусламж, 6202 хүнд жирэмсэн нярай хөхүүл хүүхэдтэй эхийн мөнгөн тэтгэмжийг зарцуулсан байна.



## АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО

2016 оны 7 дугаар сард татварын хэлтсийн мэдээлэл боловсруулалтын санд бүртгэлтэй аж ахуй нэгж байгууллагын тоо 15377 болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.5 хувиар буюу 797 аж ахуй нэгж байгууллагаар нэмэгдсэн байна. Нийт бүртгэгдсэн аж ахуй нэгж байгууллагын 77.3 хувь буюу 11882 байгууллага нь ХХК байна. Оны эхнээс нийт 787 байгууллага шинээр бүртгэгдэж, 597 байгууллага хасагдсан байна.

Хүснэгт 12. Аж ахуй нэгж байгууллагын тоо

ААНБ-ын төрөл	ААНБ-ын хариуцлагын хэлбэр	2015.07	2016.07
ААН	ХК	10	19
	ХХК	11369	11882
	ББН	118	127
	ЗБН	87	93
	ХХН	32	43
	Хоршоо	54	48
	Хадгаламж зээлийн хоршоо	67	59
	Төрийн өмчит үйлдвэрийн газар	29	33
	ОНӨҮГ	7	12
	Салбар	731	724
	Төлөөлөгчийн газар	8	20
	Төлөөний газар	1	3
	Боловсролын сургалтын байгууллага	1	1
	Нийт	12514	13058
Төсөв болон ТББ	Төсөвт байгууллага	264	284
	Төрийн бус байгууллага	1475	1683
	Шашны байгууллага	40	42
	Сан	90	104
	Олон нийтийн байгууллага	197	206
	Нийт	2066	2319
Бүгд		145580	15377



АЖ ҮЙЛДВЭР


Аж үйдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2016 оны 7 сард 1017.8 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 40.0 хувь буюу 290.7 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь хувцас үйлдвэрлэл 35.3 хувь, хэвлэлийн үйлдвэрлэл 28.7 хувь, бусад үйлдвэрлэл 211.6 хувиар өсч, хүнс үйлдвэрлэл 18.4 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 13. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн /сая.төг/

Салбар		2015.07	2016.07	Өсөлт, бууралт/%/	Зөрүү
Бүгд		<b>727.1</b>	<b>1017.8</b>	<b>40.0</b>	<b>290.7</b>
Үүнээс:	Хувцас үйлдвэрлэл	265.2	358.7	35.3	93.5
	Хүнс үйлдвэрлэл	64.3	52.5	-18.4	-11.8
	Хэвлэлийн үйлдвэрлэл	345.7	444.9	28.7	99.2
	Бусад үйлдвэрлэл	51.9	161.7	211.6	109.8

2016 оны 7 дугаар сарын байдлаар нийт үйлдвэрлэлийн 35.2 хувийг хувцас үйлдвэрлэл, 5.2 хувийг хүнс үйлдвэрлэл, 43.7 хувийг хэвлэлийн үйлдвэрлэл, 15.9 хувийг боловсруулах салбарын бусад үйлдвэрлэл эзэлж байна.

Зураг 12. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн



### ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

2016 оны 7 дугаар сарын байдлаар 4848.5 мян.м<sup>2</sup> зам талбай цэвэрлэж, 64.3 мян.м<sup>3</sup> хог тээвэрлэсэн байна. Өнгөрсөн оноос цэвэрлэсэн талбай 741.1 мян/м<sup>2</sup> буюу 13.3 хувиар буурч, тээвэрлэсэн хог 4.7 мян/м<sup>3</sup> буюу 7.9 хувиар өссөн байна. Ажил үйлчилгээний орлого 3990.7 сая төгрөг болж өнгөрсөн оноос 693.4 сая төгрөг буюу 23.1 хувиар өссөн байна. Орлогын эх үүсвэрийг ангилвал 18.4 хувийг зам талбай, 36.7 хувийг гэр хорооллоос, 20.4 хувийг орон сууцнаас, 24.5 хувийг албан газраас тус тус олсон орлого эзэлж байна.

### Хүснэгт 14. Тохижилтын ажил

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015.07	2016.07	Зөрүү	%
Цэвэрлэсэн талбай	мян.м <sup>2</sup>	5589.6	4848.5	-741.1	13.3
Тээвэрлэсэн хог	мян.м <sup>3</sup>	59.6	64.3	4.7	7.9
Үүнээс:					
Орон сууц	мян.м <sup>3</sup>	14.9	16.1	1.2	8.0
Гэр хороолол	мян.м <sup>3</sup>	26.8	29.0	2.2	8.2
Албан газар	мян.м <sup>3</sup>	8.9	9.7	0.8	9.0
Зам талбай	мян.м <sup>3</sup>	8.9	9.7	0.8	9.0
Ажил үйлчилгээний орлого	сая.төг	2997.3	3690.7	693.4	23.1
Үүнээс:					
Зам талбай	сая.төг	507.3	679.0	171.7	33.8
Гэр хороолол	сая.төг	1159.0	1355.3	196.3	16.9
Орон сууц	сая.төг	686.0	752.9	66.9	9.7
Албан газар	сая.төг	645.0	903.5	258.5	40.1



## ТӨРИЙН БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ

### ИРГЭНИЙ БҮРТГЭЛ

Чингэлтэй дүүргийн Бүртгэлийн хэлтэс нь 2016 оны 7-р сарын байдлаар иргэний бүртгэлийн 8 төрлийн үйлчилгээг 11814 иргэнд үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 41.6 хувиар, буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 15. Иргэний бүртгэлийн мэдээ

Үзүүлэлт		2015.07	2016.07
Нийт		20252	11814
Шинэ төрсөн		2655	2274
Гэрлэлт		484	518
Гэр бүл цуцлалт		184	168
Хүүхэд үрчлэлт		51	30
Эцэг тогтоосон		1212	1078
Овог, нэр өөрчлөх		114	126
Иргэний үнэмлэх олголт	16 нас хүрч шинээр авсан	894	1412
	дахин олголт	3538	4080
Шилжилт хөдөлгөөн	шилжин ирсэн	4785	1344
	шилжин явсан	6335	784

### ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ

Чингэлтэй дүүргийн Бүртгэлийн хэлтэс нь 2016 оны 7-р сарын байдлаар 1776 иргэн, аж ахуй нэгж байгууллагад эд хөрөнгийн бүртгэлийн 5 төрлийн үйлчилгээг үзүүлж, үйлчилгээний хөлсөнд нийт 19.0 сая төгрөг хураасан байна.

Хүснэгт 16. Эд хөрөнгийн бүртгэлийн мэдээ

Үзүүлэлт	Үйлчлүүлсэн тоо			Үйлчилгээний хөлс /мян.төг/		
	Нийт	Газар	Газраас бусад	Нийт	Газар	Газраас бусад
Нийт	1776	1139	637	19006777	6371993	12634784
Анхны бүртгэл	145	95	50	30000	30000	0
Өмчлөх эрх шилжих гэрээ	297	188	109	7212000	4484000	2728000
Барьцааны гэрээ	1214	761	453	10767777	1068993	9698784
Бусад гэрээ	2	1	1	40000	20000	20000
Лавлагаа, хуулбар	118	94	24	957000	769000	188000

## ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2016 оны 7 сарын байдлаар Дүүргийн Засаг даргын 17 удаагийн захирамжаар 415 иргэний газрын эрхийг баталгаажуулж, газар эзэмших эрхийн нэр шилжүүлэх, талбайг өөрчлөх, хугацаа сунгах зэрэг газрын асуудлыг шийдвэрлэсэн байна.

Тайлант хугацаанд зуслангийн газар өмчлүүлж эхэлсэнтэй холбогдуулан иргэдээс /www.land.ulaanbaatar.mn/ цахим сайтад бүртгүүлсэн 1500 иргэний бүртгэлийг шүүж тухай бүрт хариу өгч ажиллаж байна.

### Хүснэгт 17. Үзүүлсэн үйлчилгээ

№	Нэр	Тоо
1	Мэдээллийн санд нэр сольсон	260
2	Нэр сольсон	16
3	Хаяг сольсон	0
4	Хаяг оруулсан	40
5	Байшин оруулсан	123
6	Талбай хассан	26
7	Талбай нэмсэн	11
8	Өмчилсөн газар хуваасан	25
9	Зураг нийлүүлсэн	1
10	Томоор орсон зураг хуваасан	17
11	Зураг өөрчилсөн	42
12	Шинээр оруулсан	227
13	Эзэмшлийн хэлбэр өөрчилсөн	3
14	Захирамж тэмдэглэсэн	13
15	Бүртгэл оруулсан	2
16	Барьцаа бүртгэсэн	51
17	Барьцаа чөлөөлсөн	21
18	Регистр зассан	5
19	Өмчлөлийг тэмдэглэсэн	61
20	Байршил өөрчилсөн	10
21	Бусад	9
21	Архивын хавтас үүсгэсэн	20
	<b>НИЙТ</b>	<b>983</b>

2016 он гарсаар газрын төлбөрийн 170.0 сая төгрөг, газрын гэрчилгээний төлбөр 8.5 сая төгрөг, бусад бүртгэлээс 1.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.



### МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТ

Тус хэлтэс нь 2016 оны 7 сарын байдлаар нийт 858 нэгжид шалгалт, 782 нэгжид хяналт хийж гүйцэтгэсний 67.1 хувь нь ААНБ-г, 32.9 хувь нь иргэнийг хамарсан байна.

Хүснэгт 18. Хяналт, шалгалт, зөрчил, торгуул шийтгэвэрийн мэдээ, тасгаар


Үзүүлэлт		Нийтдүн	ХХААҮҮБОХ- ынтасаг	ЭМБХ- ынтасаг	ХНХХ- ынтасаг
Хяналт	ААНБ	437	113	324	0
	Иргэн	345	203	142	0
	Дүн	782	316	466	0
Шалгалт	ААНБ	663	379	259	25
	Иргэн	195	162	30	3
	Дүн	858	541	289	28
Хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил	Нийт илэрсэн	1080	547	530	3
	Арилгасан	677	341	334	2
Торгууль, шийтгэвэр	Тоо	153	89	64	0
	Үнийн дүн мян.төг	22158	10500	11658	0
Зөвлөн туслах сургалт, сурталчилгаа	ААНБ	219	119	87	11
	Иргэн	445	95	350	0
	Дүн	694	214	437	11

Энэ хугацаанд нийт 1080 зөрчил илэрсний 648 буюу 62.7 хувийн зөрчлийг арилгасан ба нийт 153 торгууль, шийтгэвэрт нийт 22.1 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Зураг 13. Хийсэн хяналт тоо, тасгаар



Зураг 14. Хийсэн шалгалтын тоо, тасгаар



## УЛААН ЗАГАЛМАЙН ЧИГЛЭЛЭЭР

Дүүргийн “Улаан загалмайн хороо” 2016 оны 7-р сард нийт 498 хүнд 10 удаа 443.3 мян.төгрөгийн халамж үйлчилгээ үзүүлсэн байна. Халамжийн үйлчилгээ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 413.3 мян.төгрөгөөр нэмэгдсэн боловч 496 хүнээр буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 19. Зохион байгуулсан арга хэмжээ, хамрагдсан хүн зардалаар

Үзүүлэлт	2015 он 07-р сар			2016 он 06-р сар		
	Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо	Зардал /мян.төг/	Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо	Зардал /мян.төг//
Халамж үйлчилгээ	1	2	30000	5	19	443300
Анхны тусламжийн сургалт	13	992	-	2	60	
Гамшгийн тусламж						
Донорын өдөрлөг				3	419	
Дүн	14	994	30000		498	443300

Мөн анхы тусламжийн 2 удаагийн сургалт зохион байгуулж, сургалтанд нийт 60 иргэн, донорын өдөрлөг арга хэмжээг 3 удаа зохион байгуулж 419 иргэнийг хамруулсан байна.

## АХМАДЫН ХОРОО

Тулгар төрийн 2225, Их монгол улс байгуулагдсаны 810, Ардын хувьсгалын 95 жилийн ой , үндэсний их баяр наадмын ажиллагаанд амжилттай оролцож 7-р сарын 10 нд “дээлтэй монгол” наадамд 2,5,6,7,8,10,12,14,18-р хороодоос 68 ахмад настныг үндэсний хувцас одон медальтайгаар оролцуулав.

Оросын холбооны улсын Якутаас дүүргийн ЗДТГ-ын урилгаар айлчилж ирсэн 13 зочид төлөөлөгчидтэй уулзалт зохион байгуулж харилцан урлагийн тоглолт зохион байгуулж, 390 мянган төгрөгийн гарын бэлэг гардуулж дурсгалын зураг авахуулав.

Амьдралын боломж муутай 161 ахмад настнуудыг хороодын тодорхойлолтын дагуу дүүргийн халамжийн хэлтэстэй хамтран 6 хоногийн хөнгөлттэй амралтанд явуулав.

Өрхийн эмнэлгүүдийн шугамаар 312 ахмад настнуудыг эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулав.

Хороодын Ахмадын зөвлөлүүдийн шугамаар 182 ахмад настан ОХУ-ын Буриадын нутаг, Итгэлт Хамба-Байгаль нуур Улаан –Уд хотын аялалд тус тус хамруулав.



### СОЁЛ УРЛАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2016 оны 7-р сарын байдлаар Чингэлтэй дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэс:

- Соён гэгээрүүлэх үйл ажиллагаа 7-р сард зоион байгуулж нийт 371 хүүхэд багачууд хамрагдсан байна.

Дүүргийн Засаг даргын 3 удаагийн захирамжаар 3 хүүхэд асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоогдсон байна.

ХҮҮХЭД, ГЭР БҮЛ ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ

Хүүхэд, гэр бүл хөгжлийн төв нь 2016 оны 7-р сард нийт 119 хүнд хүрч ажилласан байна.

ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ

2016 оны 07 сарын байдлаар дүүргийн Засаг даргын тамгын газарт иргэдээс 100 өргөдөл, гомдол ирснээс 69-г хуулинд заасан хугацаанд нь шийдвэрлэсэн байна. Шийдвэрлэх хугацаа болоогүй, шийдвэрлэх шатандаа явж байгаа 31 өргөдөл, гомдол хянагдаж байна.

Хүснэгт 20. Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ

Ангилал	НИЙТ	Шийдвэрлэх шатандаа байгаа			Шийдвэрлэж хариу өгсөн		
		Хугацаан даа байгаа	Хугацаа хэтэрсэн	Бүгд	Хугацаан даа байгаа	Хугацаа хэтэрсэн	Бүгд
1800-1200 тусгай дугаарын утас	14	1	0	1	13	0	13
www.ub1200.mn цахим хуудас	2	2	0	2	0	0	0
Засгийн газрын 11-11 төв	31	10	0	10	21	0	21
Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв	25	10	0	10	15	0	15
Нутгийн захиргааны байгууллагууд	28	8	0	8	20	0	20
Smart UB аппликейшн, Clean UB аппликейшн	0	0	0	0	0	0	0
Мессеж	0	0	0	0	0	0	0
<b>НИЙТ</b>	<b>100</b>	<b>31</b>	<b>0</b>	<b>31</b>	<b>69</b>	<b>0</b>	<b>69</b>

## ГЭМТ ХЭРЭГ

2016 оны 7 сарын байдлаар дүүргийн хэмжээнд нийт 1500 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2.7 хувиар буюу 39 тохиолдлоор өссөн.

### Хүснэгт 21. Гэмт хэрэг

Төрөл		Цагдаагийн I хэлтэст бүртгэгдсэн				Цагдаагийн II хэлтэст бүртгэгдсэн			
		2015.07	2016.07	Илрүүлэлтийн хувь	Хувь%/	2015.07	2016.07	Илрүүлэлтийн хувь	Хувь%/
Хэргийн ангилал	Хөнгөн	395	474	61.6	20	242	220	80.8	-9.1
	Хүндэвтэр	438	334	53.4	-76.2	269	368	42.7	36.8
	Хүнд	60	46	73.3	-23.3	29	25	88.9	-13.8
	Онц хүнд	21	17	66.7	-19	7	16	87.5	1.2 дах
Гэмт хэргийн төрөл	Хүн амь					5	9	100	80
	Учрал	3				5	8		60
	Залилан	152	164	68.8	7.9	25	22	88.9	-12
	Хүчин	1	3	66.7	200	6	9	100	50
	Танхай	76	40	61.5	-47.4	34	29	70.6	-14,7
	Булаалт	7	9	37.5	28.6	4	6	50	50
	Хулгай	263	308	46.9	17.1	205	290	42.6	41,5
	ББМГУ	121	164	84.6	35.5	166	158	90.5	-4.8
	Дээрэм	13	23	65	76.9	11	14	81.8	27,3
	ТХХАББАЖЗ	60	50	94.7	-16.7	47	30	90	-36.2
	Бусад	218	110	62.1	-49.5	39	54		38.5
<b>Бүгд</b>	<b>914</b>	<b>871</b>	<b>58.9</b>	<b>-4.7</b>	<b>547</b>	<b>629</b>	<b>53.6</b>	<b>15</b>	

## ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ ЗӨРЧИЛ

Тус тасгийн алба хаагчдын гудамж замд хийсэн хяналт шалгалтаар 2016 оны 7 сард нийт 4799 зөрчил илрүүлсэнээс Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 27.1 дэх хэсгийн заалт зөрчин согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 142 мөн хуулийн 31.2,3, 32.2, 43.2, 52.1 дэх хэсгүүдэд заасан зөрчилтэй 19 тээврийн хэрэгслийг түр саатуулан журамлан Жолоочийн даатгалын тухай хуулийн 28.1.1 дэх хэсэгт заасан зөрчилтэй 0, улсын дугаарын хязгаарлалт 812, бүрэн бус 231, хамгаалах бүс хэрэглээгүй 675, нийт 4464 жолоочийг 104.709.500 төгрөгөөр торгож ажиллав. Замын Цагдаагийн газар болон бусад албадаас зарлагдсан 0 дугаарыг илрүүлэн ерөнхий жижүүрт хүлээлгэн өгсөн. Цагдаагийн шалгах төхөөрөмж ашиглан 2013 оны А/130 дугаар тушаалаар баталсан “Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих журам”-ыг хэрэгжүүлж ASAP санд бүртгэлтэй сэжигтэн яллагдагч тээврийн хэрэгсэл ашиглан хөдөлгөөнд оролцож байсан 1, Цагдаагийн нийтлэг үүргээр 1 зөрчил тус тус илрүүлсэн.

## АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ, ГАМШИГ

Хэлтсийн Аврах, гал унтраах 10 дугаар анги нь 2016 оны 7 дугаар сарын байдлаар 209 удаагийн 5352 цагийн харуул ээлжийн үүрэг гүйцэтгэх явцад гамшиг ослын дуудлагаар 542 удаа гарснаас удаагийн гамшгийн голомтод 340 удаа ажиллаж гал түймэр дээр нийт 163.1 цаг ажиллаж 422.9 тонн ус, 900 л хөөс шатах тослох материал дизель түлш 17.2 мянган литр буюу 28.7 сая төгрөгийг зарцуулан аж ахуй нэгж байгууллага, иргэдийн 3.9 тэрбум төгрөгний өмч хөрөнгийг авран хамгаалж, 171 гал түймрийг иргэд унтрааж, 3 гал түймэр өөрөө унтарч, худал дуудлагаар 15 удаа тус тус гарч ажиллан 243 байшин, барилга, 179 хүний амь насыг авран хамгаалсан байна.



## СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ:

[WWW.1212.MN](http://WWW.1212.MN)

[WWW.UBSTAT.MN](http://WWW.UBSTAT.MN)

[WWW.CHINGELTEI.GOV.MN](http://WWW.CHINGELTEI.GOV.MN)



*Хянасан: Тасгийн дарга Д.МӨНХЗУЛ*

*Танилцуулга нэгтгэсэн:  
мэргэжилтэн Т.Хаш-Эрдэнэ*

И-мэйл хаяг: [chingeltei@nso.mn](mailto:chingeltei@nso.mn)

Хаяг: Улаанбаатар хот,  
Чингэлтэй дүүрэг,  
Нийслэлийн төр захиргааны  
III байр 401 тоот  
Утас: 70113013  
70130767  
11-310767